

Дэлхийн улс-нэрийн утга

Л.Бэгзжав

Галын орон-Азербайжан

Ази,Европ хоёр тив дамнасан Ар их Кавказын уулсын зүүн хэсэгт, зүүгээрээ Каспийн тэнгис, баруун өмнүүрээ Иран, Турктай, баруугаараа Армен, хойгуураа Орос, Гүрж улстай хиллэдэг. Бүгд Найрамдах Азербайжан улс (The Republic of Azerbaijan) нь Ази тивийн газрын зураг дээр шинээр тэмдэглэгдсэн цаг хугацаа нь 1991 онд тусгаар тогтносон улс болсоноо зарласан тэр цагаас хойш юм.

Өөртөө засах Бүгд Найрамдах Уулын Карабах буюу Нахчыван улсыг хамаардаг Азербайжаны газар нутгийн хэмжээ Монгол улсынхаас 18 дахин бага буюу 86,6 мянган км², хүн ам нь манайхаас 3,4 дахин олон буюу 9 сая 165 мянга(2011) аж. Өөрөөр хэлбэл, тус улс газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 111-р байрт, хүн амын тоогоороо 89-р байранд байна.

Абхаз, авар, гүрж, курд, дагестан, татар, талыш, украин зэрэг 43 үндэстэн ястан бүхий Азербайжаны хүн амын 90,6% нь азербайжан, 2,2% нь дагестан, 1,8% нь орос, 1,5% нь армен юм.

Хүн ам нь Ислам шашны шийт урсгалыг шүтдэг Азербайжан улсын нэр нь араб хэлээр галт газар, галын орон гэсэн утгатай. Угтаа бол перс хэлний арабжсан хэлбэр буюу визант, грек, сири хэлнээ авиа сэлгэсээр эртний иран хэлний Атурпата буюу ариун гал гэсэн утгатай үг цагийн аяст хувиран үндсэн утгаа хадгалсаар Атурпаткан-Адарбеган-Азербайжан болсон түүхтэй.

МЭ VII-VIII зуунд Арабын халифт Ираныг эзэлсэнээр араб хэлний нөлөөгөөр Азербайжан гэгдэх болсон ба зарим эрдэмтэд персийн газрын нэр зүйн туркжсэн хэлбэр гэж үзэх нь ч бий.

Азербайжанууд гал тахих ёслол үйлдэж, галыг бурхан сахиулсан гэж шүтдэг. Эндэхийн газар дээр шатаж унтардаггүй галыг хаанаас ч үзэж болно гэлцдэг. Умарт нутгуудад улалзаж буй галыг тахидаг ариун сүм байдаг. Тус орны хамгийн том баяр болох 3-р сарын 20-21 нд тэмдэглэдэг “Хаврын баяр”-аар азербайжанчууд нар шингэсэний дараа хашаа хүрээндээ түүдэг гал асааж, хөгшин залуугүй бүжиглэн дуулж, өнгөрсөн нэг жилийнхээ муу бүхнийг үлдэн хөөдөг заншилтай аж.

Азербайжаны эртний түүх ээдрээтэй, харь гүрний эрхшээл дунд өнгөрсөн байдаг. МЭ III зууны үед Персийн хаант улсын нэг хэсэг байсан ба VII зууны үед Арабчуудад

эзлэгдэн, исламын соёлын нөлөөнд бүрэн орсон. МЭ XI-XIII зуунд азербайжан үндэстэн үндсэндээ бүрэлдэн тогтсон бол XIII-XIV зуунд Их Моголын улсын Монголчуудад эзлэгдэн Хүлүгэдийн эзэнт улсын мэдэлд 200 шахам жил байсан түүхтэй. XVI-XVIII зуунд Персийн хаанчлалд /Иран/ байсан ба XVIII зууны эхээр Хаант Орос Азербайжаныг нэгтгэн авчээ. Октябрийн хувьсгалын нөлөөгөөр 1917 оны 11-р сард Азербайжанд Зөвлөлт засаг буюу Бакугийн Коммуна байгуулагдаж, 1918 оны 5-р сард Азербайжаны ардчилсан бүгд найрамдах улсыг тунхаглаж, 1922 онд ЗХУ-ын бүрэлдэхүүнд орж, 1936 онд ЗХУ-ын Холбооны Бүгд Найрамдах Улс болон түүхийн ээдрээтэй урт зам туулсаар 1991 онд ЗХУ задарсанаар тусгаар тогтнолоо зарласан юм.

Газрын тосны үйлдвэрлэл, хөвөнгийн тариалалт нь Азербайжаны эдийн засгийн гол хоёр тулгуур бөгөөд тиймээс ч Азербайжанчууд “хар алт, цагаан алтны эх орон” гэж газар нутгаараа бахархдаг.

Азербайжанд бүр МЭ IX-X зуунд газрын тос олборлож байсан ба нийслэл Баку хотын газрын тос үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлж, 1901 онд дэлхийн газрын тосны бараг тал хувийг, Оросын газрын тосны 95%-ийг олборлож байжээ.

2 сая гаруй хүн амтай Бакуг “газрын тосны хот” гэдэг. Баку болон эргэн тойрны 40 гаруй хотын ард түмний амьдрал үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагаа газрын тостой шууд болон дам холбоотой. Бакуг төв болгосон Апшероны хойг түүний ойролцоох нутаг бол дэлхийд нэртэй газрын тосны үйлдвэрлэлийн район бөгөөд 100 гаруй жил Оросын газрын тосны үйлдвэрлэлийн бааз байж, Оросын аж үйлдвэрийн хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тус улсын газрын тосны нөөц нь 350-400 тэрбум тн бөгөөд газрын тос нь хольц багатайгаараа онцлог аж. Баку нь 1950-иад оны дунд үеэс өмнө газрын тос үйлдвэрлэлийн хэмжээгээр ЗХУ-д тэргүүн байранд байв. Бакугийн нефть-химийн дээд сургуулийг дүүргэсэн Монгол хүн цөөнгүй бий.

Азербайжан улс нь хөвөн нэхмэл, торгон нэхмэл, ноосон нэхмэл, хивс үйлдвэрлэлээрээ бүс нутагтаа төдийгүй дэлхийд ч нэртэй.

Газар нутгийн ихэнхийг өндөр уулс эзэлдэг тус орны өөр нэг нэрийг “уулын орон” гэх бөгөөд тус оронд Каспийн тэнгис нэртэй ч тэнгис биш, дэлхийн хамгийн том давст нуур байдаг онцлогтой. Энэ нуур хойноосоо урагш 1200 км, зүүнээсээ баруунш 320 км, 396 мянган км² талбайтай. Дэлхийн бүх нуурын хэмжээ 2,7 сая км² байдгийн 14%-ийг Каспийн тэнгис эзэлнэ.

Монгол Улс, Бүгд Найрамдах Азербайжан улстай 1992 оны 4-р сарын 16-нд дипломат харилцаа тогтоосоноор Азербайжан улс нь манай улсын 118 дахь дипломат харилцаатай орон болсон байна.

2012.01.02

Л.Бэгзжав

Ашигласан ном хэвлэл

1. Материал из Википедии-свободной энцикло-педии
[http://ru.wikipedia.org/wiki/ Азербайджан](http://ru.wikipedia.org/wiki/Азербайджан)
2. Атлас мира. М;2006 “Аст-пресс школа” хэвлэлийн газар. 179-р тал
3. “神秘亚细亚”(Нууцлаг Ази) Бээжин 2011, 164-166-р тал
4. “最新各国概况” Чанчун, 2007
5. Страны мира. Энциклопедический справочник. Минск, 2011